



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/204

Улаанбаатар хот

Бараа материал худалдах,
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.1.5 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны албаны дулааны станцын үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглагдаж байсан 1,767.77 тн нүүрсийг 1 тонн тутмыг 74,980 төгрөг, нийт 132,547,394.60 (нэг зуун гучин хоёр сая таван зуун дөчин долоон мянга гурван зуун ерэн дөрвөн төгрөг жаран мөнгө) төгрөгөөр “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-д худалдан борлуулж, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэхийг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т зөвшөөрсүгэй.

2. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Аэродромын албанд ашиглаж байсан 360,000 (гурван зуун жаран мянган) төгрөгийн өртөг бүхий 300 ширхэг хийн бууны сумыг цагдаагийн байгууллагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилжүүлэн, хүлээлгэн өгөхийг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга, Өмч хамгаалах зөвлөл (Н.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 1178